



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 42

Сүхбаатар сум

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны ажлын тайлангийн тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны ажлын тайланг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд нийт 75 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 60 ажил арга хэмжээг хийж гүйцэтгэл 80 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг 4 удаа зарлан хуралдуулж аймгийн эдийн засаг, нийгмийн салбар хүрээг хамарсан 18 асуудал хэлэлцэж 18 тогтоол, Тэргүүлэгчдийн хуралдааныг 17 удаа хуралдуулж 180 гаруй асуудал хэлэлцэж 163 тогтоол гаргасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь эрчимжсэн мал аж ахуй газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгох саналыг Монгол Улсын Засгийн газарт уламжлан, “Эрчимжсэн үхрийн аж ахуй хөтөлбөр”, “Сүхбаатар, Мандал сумын агаар, орчны бохирдлыг бууруулах ерөнхий төлөвлөгөө”, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, 2018 оны үндсэн чиглэл, 2017 оны төсвийн тодотгол, 2018 оны төсөв зэрэг аймгийн эдийн засаг нийгмийн тулгамдсан чухал асуудлуудыг хэлэлцүүлэн зохих шийдвэрүүдийг гаргуулжээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг салбараар авч үзвэл эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын 15 асуудал, Орон нутгийн төсөв өмчийн талаар 17 асуудал, байгаль орчны бодлогын асуудал 8, нутгийн удирдлага, нийгмийн дэг журам нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 12 асуудал, иргэдийн ажил амьдрал, санал хүсэлттэй холбоотой асуудал 5, хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдох асуудал 3, иргэдийг шагналд уламжлах, ой тэмдэглэх, сүм хийдийн зөвшөөрөл олгох, нэрэмжит болгох зэрэг 120 гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлын дотор аймгийн Засаг дарга түүний удирдлагын багаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусган баталсан богино, дунд

хугацааны бодлогын хөтөлбөрүүдийн 80 гаруй хувийг хэлэлцэн баталж үйл ажиллагааг эхэлүүлсэн нь сайшаалтай байна.

2017 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчид, зарим Бодлогын хороод 3 байгууллага, 6 суманд ажиллаж хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах, хэрэгжилтийн явцтай газар дээр нь үзэж танилцан, иргэдтэй уулзан санал бодлыг нь сонсож ажиллажээ.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан Хурлын үйл ажиллагаанд орчин үеийн техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн цахим хурал болох стратеги зорилтын хүрээнд хурлын Төлөөлөгчдөд нийт 57 сая төгрөгөөр iPad авч өгсөн нь хурлаар хэлэлцэх асуудал, тогтоол шийдвэрийн төсөл болон шаардлагатай бусад мэдээ мэдээллийг Төлөөлөгчдөд цахимаар түргэн шуурхай хүргэхэд цаг хугацаа, зардал төсөв хэмнэсэн чухал дэвшил болжээ.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Тэргүүлэгчид, Багийн иргэдийн нийтийн хурлын дарга, Нарийн бичгийн дарга нарт зориулан Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэх, төлөөлөгчдийн мэдлэг чадварыг сайжруулах зорилго бүхий сургалт зөвлөгөөн, семинаруудыг давхардсан тоогоор нийт 500 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан байна.

Хууль тогтоомж, холбогдох дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг чиглэл болон хурлаар хэлэлцэх асуудлыг аймаг, сумдын иргэний танхимаар хэлэлцүүлэх, санал асуулга авах зэргээр Хурлын ажлын ил тод нээлттэй байдлыг хангах, тогтоол шийдвэрт иргэдийн саналыг тусгах ажлуудыг зохион байгуулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны ажлын тайланг дүгнээд Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "в", 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үнэлсүгэй.


Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд ДААЛГАХ нь:

1.Хурлын төлөөлөгчид, Тэргүүлэгчид, Бодлогын хороодын ажлыг идэвхижүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016-2020 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд тусгагдсан зорилго зорилт, ажил арга хэмжээг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;

2.Аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай бодлого шийдвэр, хяналтаар дэмжлэг үзүүлэх;

3.Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь эрчимжсэн мал аж ахуй газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгох саналыг төр засаг, ард иргэдэд зөв ойлгуулан таниулах, эрх бүхий байгууллагаас зохих шийдвэрийг гаргуулахад шаардлагатай боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Гурав.Хурлаас дэвшүүлсэн зорилт, батлан гаргаж буй аливаа бодлого шийдвэрийг аймаг орон нутгийн хэмжээнд далайцтай өрнүүлж хэрэгжүүлэн, ард иргэдэд зөв ойлгуулан таниулж Хурлын ажлыг тогтмолжуулан сайжруулахад шинэ санал санаачилга гарган идэвхитэй ажиллахыг Хурлын нийт төлөөлөгчид, Бодлогын хорооны дарга нарт уриалсугай.

ДАРГА  Б.БЯМБАА